


Багш /90 мин\

1. Аль судалгаа нь хүмүүсийн өдөр тутмын амьдрал, харилцан үйлдлийг судалсан байна вэ?
 - a. Хөдөөгийн малчин хүн амын орлогын эх үүсвэрүүдийг тогтоох
 - b. АНУ-д арьс өнгөөр ялгаварлан гадуурхах хандлагын тархалтыг тодорхойлох
 - c. Сонгодог урлагийн талаарх хүмүүсийн субъектив утгын ялгааг ойлгох
 - d. Монголчуудын гэрлэлтийн хэв маягийг тодорхойлох судалгаа
2. "Нийгэм өөрөө өөрийгөө хангагч систем" гэсэн бодомжийн утгыг аль бодомж илүү илэрхийлж байна вэ?
 - a. Нийгэм нь өөр хоорондоод харилцан холбоотойгоор сүлжилдсэн элементүүдээс тогтдог мөн чанартай
 - b. Нийгмийн дотоод элементүүд нь харилцан бие биенийхээ хэрэгцээг хангах замаар оршдог бөгөөд хойч үеэ бэлтгэн нийгэмшүүлэх замаар урт удаан хугацаанд оршин тогтнодог
 - c. Нийгэм нь өөрийн соёл, үнэт зүйлсээ хойч үедээ өвлөн залгамжлуулах замаар оршин тогтнодог
 - d. Бүхий л хэрэгцээгээ дотооддоо хангах чадамжтай болохыг
3. Амиа хорлолт нь нийгмийн шинжтэй үзэгдэл юм гэж үзэж байгаагийн гол утга юу вэ?
 - a. Нийгэм бүрд амиа хорлох үзэгдэл гардаг тул
 - b. Нийгмийн олон хүчин зүйлсийн нөлөөгөөр амиа хорлолтын түвшин өөрчлөгдөж байгаа тул
 - c. Сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн үйлдэл болохоор
 - d. Нийгмийн гишүүний хийж буй үйлдэл тул
4. Нийгмийн давхраажилтыг объективээр хэмжиж байгаа нь аль нь вэ?
 - a. Та аль давхраанд хамаарах вэ гэж асуух
 - b. Тодорхой ажил мэргэжлийн төрлийг үнэлж байгаа нь
 - c. Та сарын хэдэн төгрөгийн орлоготой вэ?
 - d. Хүмүүс хэнийг хүндэлж байна вэ?
5. Зорилтот түүврээс санамсаргүй түүврийн ялгагдах гол ялгаа юу вэ?
 - a. Бүх нэгжээс тааралдсаныг нь сонгох
 - b. Бүх нэгжид судалгаанд оролцох боломжийг тэгш олгон сонгох
 - c. Тодорхой онцлог нэгжийг сонгох
 - d. Тодорхой нийтлэг шинжийг илтгэх нэгжийг сонгох
6. Аль хувьсагч нь тасалдалттай буюу дискрет байна вэ?
 - a. Нас
 - b. Биеийн өндөр
 - c. Жин
 - d. Ажилчдын тоо
7. Ажил эрхэлдэг хүн амын 21.4 хувь нь бага, 61.2 хувь нь дунд, 11.2 хувь нь мэргэжлийн, 6.2 хувь нь дээд боловсролтой байна. Харин ажил эрхлээгүй хүн амын 13.7 хувь нь бага, 63.7 хувь нь дунд, 3.9 хувь нь мэргэжлийн 18.7 хувь нь дээд боловсролтой гэж үзвэл эндээс ямар дүгнэлт хийвэл оновчтой байна вэ?
 - a. Ажил эрхэлдэг ба ажил эрхлээгүй хүн амын хооронд ялгаа ажиглагдаж байна.
 - b. Дээд боловсролтой хүн ам ажилгүйдэлд өртөмхий байна.
 - c. Бага боловсролтой хүн ам ажил эрхлэх нь илүү байна
 - d. Б болон В хариулт зөв
 - e. Бүгд зөв
8. Гаж зан үйлийг тодорхойлсон дараах тодорхойлолтуудаас хамгийн оновчтой нь аль вэ?
 - a. Нийгмийн хэм хэмжээг зөрчсөн зан үйл
 - b. Олонхоос тогтоосон зан үйлийн хэм хэмжээ, хүмүүсийн хүлээлтэд үл нийцэх зан үйл
 - c. Олны жишгийг дагах, аяыг дагах, тогтсон чиг шугамын дагуу биеэ авч явах явдал
 - d. Буруу гэгдэх үйлдлүүдийг хийх
9. Олон судлаачид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нийгмийн хяналтын функцыг судалсан байдаг. Судлаач Т.Хирш нийгэмтэй холбогдох холбоо нь эзэнгшил, хүсэл эрмэлзэл, оролцоо, итгэл үнэмшил гэсэн 4 элементтэй. Хувь хүний нийгэмтэй холбогдох холбоо хүчтэй байвал гэмт хэрэгт орооцолдохоос сэргийлнэ гэжээ. Дараахын аль нь эзэнгшлийн утгыг илэрхийлж байна вэ?

- a. Гэр бүл, сургууль, шашин, орон нутгаас зохион байгуулах үйл ажиллагаанд хамрагдах
 - b. Эцэг эх, багш, бусад хүмүүсийн итгэл хүндэтгэлийг авч, амлалт авах
 - c. Нийгэмд тогтсон үнэт зүйлс, үзэл санааг өөртөө ат бөх хүлээн авч бэхжүүлэх
 - d. Өөр хоорондоо сэтгэл зүй, сэтгэл хөдлөлийн холбоо тогтоосон гэр бүл, найз нөхөд, клуб зэргийн гишүүн байх
10. Аль жишээ нийгмийн давхраажилт хэмээх ойлголтын утгыг илэрхийлж байна вэ?
- a. Өмч хувьчлалын үеэр зочид буудал хувьчилж авсан Б, үйлдвэр нь цомхотгол хийсний улмаас ажилгүй болсон А нарын ялгаа
 - b. Хувьчилсан зочид буудлаа ажиллуулж чадаагүй тул дампууруулсан Б, харин БНСУ-д ажиллаж мөнгө хүримтлүүлсэн А нарын ялгаа
 - c. Хувьчилж авсан зочид буудлаа өргөтгөн үйлчилгээний газар нэмж байгуулсан Б, өргөтгөхөд нь манаачаар ажиллах болсон Б нарын харилцаа
 - d. Зочид буудал, үйлчилгээний газрыг нь "сүлжээ" болгон өргөтгөсөн Б-ийн үр хүүхэд ба ажилчин А хүүхдээ Б-ийн гэр бүлийн жолооч болгож буй харилцаа
11. Сонгогчийн зан үйлийн судалгаанд оролцогчдын дундаж нас 40.9, харин голч буюу медиан 35.6 гарчээ. Яагаад дундаж нас 5.3 насаар өндөр гарсан бэ?
- a. Өндөр настай хүн цөөн байсан ч дундаж насыг тооцоолоход нөлөөлсөн тул
 - b. Хамгийн их давтамжтай утга тул
 - c. Судалгаанд оролцогчдыг насны хувьд 50\50 хувьд хувааж буй утга тул
 - d. Залуу хүн цөөн байсан ч дундаж насыг тооцоолоход нөлөөлсөн тул
12. 2000 оны УИХ-ын Сонгуульд МАХН (одоогийн МАН) нийт сонгогчдын 52 хувийн санал авсан атлаа УИХ-ын 94.7 хувь буюу 72 суудал, харин бусад нам, эвсэл нийт сонгогчдын 48 хувийн санал авсан ч 4-хэн суудал авсан. Харин 2016 оны сонгуульд МАН нийт сонгогчдын 45.69 хувийн санал авсан атлаа УИХ-ын 85.5 хувь буюу 65 суудал, бусад нам, эвслүүд 54.31 хувийн санал авсан атлаа 11 суудал авч байжээ. Энэхүү ялалт байгуулаагүй нэр дэвшигчийн төлөө саналаа өгсөн сонгогчид парламентад төлөөлөлгүй хоцрох нь сонгуулийн аль тогтолцооны ямар сул тал вэ?
- a. Пропорциональ тогтолцооны санал гээгдэх үзэгдэл
 - b. Мажиротори тогтолцооны санал гээгдэх үзэгдэл
 - c. Пропорциональ тогтолцооны олон талт байдал алдагдах үзэгдэл
 - d. Мажиротори тогтолцооны олон талт байдал алдагдах үзэгдэл
13. Улс төрийн засаглалын легитимт шинжийг олно уу.
- a. Оновч муутай санаа бодол, сэтгэл хөдлөл дээр суурилан засаглах шинж
 - b. Улс төрийн зүтгэлтний нэр хүнд, авъяас билэгт тулгуурлан засаглах шинж
 - c. Олон нийтийн зүгээс хүлээн зөвшөөрөгдөж, дэмжлэг хүлээх шинж
 - d. Улс төрийн зүтгэлтний уламжлалт нэр хүндэд дулдуйдан дагах шинж
14. Улс төрийн намыг баримталж буй үзэл суртлаар нь хэрхэн ангилдаг вэ?
- a. Зүүний, барууны, төвийг сахисан
 - b. Эрх баригч, сөрөг
 - c. Социалист, консерватив, либерал
 - d. Орчин үеийн, уламжлалт
15. Аль нь ардчилсан сонгуулийн зарчимд хамааралгүй үзүүлэлт вэ?
- a. Бүх нийтийн зарчим
 - b. Давуу эрхийн зарчим
 - c. Санал нууцаар гаргах зарчим
 - d. Ил тод байх зарчим
16. Аль нь улс төрийн системийн оролтод хамаарах вэ?
- a. Асуудал
 - b. Хууль тогтоомж
 - c. Шаардлага, дэмжлэг
 - d. Улс төрийн шийдвэр
17. Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд тусгаснаар БНХАУ, Япон улс, БНСУ-аас бусад Азийн улстай ямар бодлого баримталж ажилладаг вэ?
- a. Олон талт хамтын ажиллагаанд оролцох
 - b. Хоёр талын найрсаг харилцаа
 - c. Стратегийн тогтвортой байдлыг бэхжүүлэх
 - d. Аюулгүй байдлын хамтын ажиллагааг өргөжүүлэх



18. Реалист онолын үүднээс олон улсын харилцааны гол оролцогч нь хэн вэ?
 а. Хувь хүн б. Улс
 с. Корпораци d. Улс төрийн клуб
19. Дараах субъектээс аль нь олон улсын төрийн бүс байгууллага вэ?
 а. Нэгдсэн үндэсний байгууллага б. Европын холбоо
 с. Соросын сан d. Шанхайн хамтын ажиллагааны байгууллага
20. Монгол улсын иж бүрэн түншлэлтэй оронд аль улс багтах вэ?
 а. Оросын Холбооны Улс б. Канад
 с. Бүгд Найрамдах Солонгос Улс d. Австрали
21. Олон улсын харилцаанд “Зөөлөн хүч”-ний үзэл санааг хөгжүүлсэн судлаач хэн бэ?
 а. Жозеф С.Най б. Самюэл Хантингтон
 с. Бенедикт Андерсон d. Бүгд мөн
22. Монгол Улсын хамтын нийгэмлэгийн байгууллага дахь оролцооны үндсэн зарчмуудын нэг болох прагматик байх зарчмын гол утгыг аль нь оновчтой илэрхийлсэн байна вэ?
 а. Олон улс оронтой хамтран ажиллах, гадаад харилцааг олон хэлбэрээр явуулах
 б. Гадаад харилцаа, хамтын ажиллагаандаа нөөц бололцоог аль болох бүрэн дайчлан зохион байгуулах
 с. Үндэсний язгуур ашиг сонирхлыг сахин хамгаалсан, үндэсний хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх
 d. Стратегийн ач холбогдол бүхий гүрнүүдийн Монгол Улс дахь эдийн засгийн болон бусад сонирхлыг тэгцвэржүүлэх
23. Монгол улс олон улсын харилцааны улс оролцогч болохын хувьд 1961 оноос өмнө ямар хэлбэрээр хүлээн зөвшөөрөгдсөн байсан бэ?
 а. Улс оролцогч б. Де факто с. Де юре d. Бүгд зөв
24. Ёс зүйд хариуцлага хэмээх ойлголт ямар утга илэрхийлдэг вэ?
 а. Алдаа гарсан тохиолдолд өөрийн гэмийг ойлгох ёс суртахууны эрмэлзэл
 б. Үйлдлийн үр дагаврыг урьдаас тооцоолох, хянах ёс суртахууны эрмэлзэл
 с. Хүмүүсийн зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх ёс суртахууны эрмэлзэл
 d. Дээрх бүгд
25. “Ethos” гэдэг үг ямар утга илэрхийлдэг вэ?
 а. Мэргэн ухаан б. Сэтгэл хөдлөл с. Ёс заншил, хэв дадал d. Шинжлэх ухаан
26. Интернет орчны ёс суртахууныг зохицуулах хамгийн үр дүнтэй хэлбэр аль нь вэ?
 а. Бүрэн хаалт хийх б. Бусдын үзэл бодлыг хязгаарлах
 с. Харилцааны дүрэм, этикетийг тогтоох d. Хэрэглэгч бүрийг хянан шалгах
27. Хиймэл оюун ухааныг ашиглахад ёс суртахууны хувьд баримталбал зохих гол зарчим аль нь вэ?
 а. Цаг хугацаагаа хэмнэх б. Нууцлал, хамгаалалт
 с. Хариуцлага, шударга байдал d. Илүү их өгөгдөл цуглуулах
28. Ёс суртахууны алтан дүрмийн шаардлага юу вэ?
 а. хувийн эрхэм чанараа бусдаар хүндэтгүүлж бай
 б. бусад хүмүүстэй харилцахдаа тэд чамтай яаж харилцаасай гэж чи өөрөө хүсдэг билээ, түүн шигээ л харилцаж бай
 с. бусдын санаа бодол, итгэл үнэмшил, сүсэг бишрэл, авир үйлдэлд ямагт хүндэтгэлтэй хандаж бай
 d. амьдралын бүх хүрээнд ёс суртахууны хэм хэмжээг баримталж бай
29. Хүн өөрийн буюу бусдын үйлдэл, сэдэл, зан авирыг сэтгэлийнхээ гүнээс буруутгах чадварыг ёс зүйд ямар ойлголтоор илэрхийлдэг вэ?
 а. Хэрсүү зан б. Нэр төр с. Ичих сэтгэл d. Гэмшил
30. Волюнтаризмын үндсэн ойлголтыг нэрлэ
 а. түршлага б. эрх чөлөө с. сонголт d. хүсэл эрмэлзэл
31. Утилитарист ёс зүй гэж юу вэ?



- а. хүний үйлдэл, зан байдлын ёс суртахууны үнэлэмж нь тэдгээр үйлдлийн ашигтай байдлаар тодорхойлогдоно гэж үздэг үзэл баримтлал
 б. ёс суртахууны үнэлэмж нь тухайн үйлдэл амьдралын практикт нийцэж байна уу, үгүй юу гэдгээр тодорхойлогдоно гэж үздэг үзэл баримтлал
 с. шинжлэх ухааны салбар болох ёс зүйг логик-лингвистик судалгааны аргаар судлах ёстой гэж үздэг үзэл баримтлал
 д. ёс суртахууны тогтвортой хэм хэмжээлэг шинжийг үгүйсгэдэг үзэл баримтлал
32. Албадлагын бүс шинжтэй хэм хэмжээг нэрлэнэ үү?
 а. хааны зарлиг б. ёс суртахуун с. төрийн хууль д. ял шийтгэл
33. Аристотелийн үзэж байснаар сайн үйлийн дээд хязгаар юу вэ?
 а. оюун ухаан б. даруу төлөв байх с. эр зориг д. шударга ёс
34. Хувь хүний соёлын бүрэлдэхүүнд хамааралгүй үзүүлэлтийг нэрлэнэ үү.
 а. Хувь хүний мэдлэгийн түвшин б. Хувь хүний овог, нэр
 с. Хувь хүний боловсролын түвшин д. Хувь хүний ёс суртахууны үнэлэмж
35. Үүргийн ёсоор үйлдэх /категорийн императив/ тухай баримтлалыг дэвшүүлсэн сэтгэгч хэн бэ?
 а. Г.Гегель б. Дж.Локк с. Т.Гоббс д. И. Кант
36. Дараах ойлголтуудаас аль нь багтаамжаараа их вэ?
 а. Соёлын хожимдол б. Соёлын хямрал с. Соёлын даяаршил д. Соёлын өөрчлөлт
37. Загварын шоуг нийтийн соёлын нэг хэлбэр гэж үзэхдээ ямар үндэслэлийг баримтлах вэ?
 а. Мэргэжлийн уран бүтээлчдийн үр чадварыг харуулдаг.
 б. Өргөн олны анхаарал татах, худалдааны зорилго, хэрэглээнд чиглэдэг.
 с. Ард түмний үе дамжсан аман уламжлал, зан заншилд тулгуурладаг.
 д. Тухайн улсын түүх, бэлгэдэл, үндэсний онцлогийг төлөөлдөг.
38. Шударга ёсны үнэлэмжид хамааралгүй жишээ аль нь вэ?
 а. Сургуулийн тэтгэлгийн талаар бүх сурагчдад тэнцвэртэй мэдээлэл өгч, өрсөлдөх боломжийг бүрдүүлэх.
 б. Ангийн хурал дээр бүх сурагчид өөрийн санал, бодлыг хэлэх эрхийг нээлттэй байлгах.
 с. Сурагчдыг ёс уламжлал, зан үйл, удам угсаагаар нь ялгаварлахгүй байх.
 д. Цахим орчны нөлөөгөөр сурагчдын зан харилцаанд гарч буй өөрчлөлтийг судлах
39. Аль нь оновчгүй томъёолол вэ?
 а. соёлын тухай философи тайлбар б. соёлын тухай философи үзэл
 с. соёлын тухай философи зарчим д. дээрх томъёолол бүгд оновчгүй
40. Дараах тэмдгүүдээс аль нь төрөлх хэлний тэмдэгт хамаарах вэ?
 А. Үг, өгүүлбэр В. Морз үсэг С. Хими, физикийн томъёо D. Фото зураг
41. Соёлын онолч Клайд Клакхоны баримтлал аль нь вэ?
 а. Соёл бол алтан дундаж, хүмүүсийн үйлдлийн хэм хэмжээ төдийгүй, бас үлэмж хүмүүсийг төрүүлж, өөд нь татдаг хүчин зүйл мөн. .
 б. Соёл бол амьдрал өөрийнхөө ачаар өөрийгөө тусгаад тодорхой ба цэгцтэй болдог амьдрах арга мөн
 с. Онцлогийг нь бүх бүлэг эзэмшсэн, ахмад үе нь хойч үедээ залгамжлуулсан буюу эсвэл өөр бүлгээс олж авсан зан төлөвийг соёл гэнэ. .
 д. Соёл бол сэтгэлийн бодит байдал, хүн төрөлхтний ухамсрын хөгжил бий болдог хүрээ мөн.
42. Матери ба ухамсрын харьцааны асуудал нь үндсэн асуудал мөн.
 а. Сонгодог бүс философийн б. Сонгодог философийн
 с. Позитивист философийн д. Постмодернист философийн
43. Бүх юмс хувирч өөрчлөгдөж байдаг гэсэн санаагаа Гераклит юу гэж томъёолсон бэ?
 а. Хүн бол бүхний хэмжүүр мөн б. Философи бол гайхахаас эхэлдэг
 с. Нэг голын усанд хоёр удаа орж болохгүй д. Би юу ч мэдэхгүй гэдгээ л мэднэ
44. Амьдралдаа нэг ч үг, өгүүлбэр бичиж байгаагүй бөгөөд харилцан ярианы (диалоги) ач холбогдлыг өндөрт өргөж байсан философич хэн бэ?



- а. Аристотель б. Платон с. Пифагор d. Сократ
45. Түүхийн мэдлэг бол баримтыг гуйвуулдаг, харин бүтэц бол түүхээс илүү объектив байдаг гэж хэн үзсэн бэ?
- а. К.Маркс б. К.Ясперс с. Б.Рассель d. К.Леви-Стросс
46. Ертөнцийг бүтээж, хувь заяаг нь удирдаж байдаг олон бүрхан тэнгэр байдаг тухай үзэл аль нь вэ?
- А. Монотеизм б. Пантеизм с. Атеизм d. Политеизм
47. Нийгмийг танин мэдэх, үнэлэмжийн дүгнэлт хийх арга зүйн зарчмыг аль нь боловсруулдаг вэ?
- а. Нийгмийн тухай шашны онол б. Нийгмийн философи
с. Нийгмийн шинжлэх ухаан d. Салбар социологи
48. Юмсын ахуйн уг сурвалж, мэдрэгдэгч юмсын ертөнцийг Бүтээгч нь Платоныхоор юу вэ?
- а. санаа с. бүрхан тэнгэр
b. матери d. байгаль
49. Аливаа юмсын ахуйн үндэс, субстанции бол материаллаг эхлэл мөн гэдэг үзлийг юу гэж нэрлэдэг вэ?
- а. Шашны трансцендентализм б. Материализм
с. Идеализм d. Дуализм
50. Үнэн гэдэг нь бидний мэдлэг бодит байдалтай тохирох явдал мөн гэж үздэг ойлголт аль нь вэ?
- а. корреспондент онол б. прагматик онол
с. когерент онол d. конвенционалист онол
51. Хүний тухай асуудлыг авч үзэхдээ “юу мэдэж чадах, юу хийх ёстой, юунд итгэх, хүн гэж юу вэ” гэсэн асуулт тавьсан философич аль нь вэ?
- а. М.Шелер б. И.Кант с. Платон d. Сократ
52. Аль нь формаль логикийн үндсэн судлагдахуун бэ?
- а. Нийгмийн үзэгдлийн шалтгаан ба үр дагаврын хамаарал б. Сэтгэцийн бүхий л үйл явц
с. Сэтгэхүйн хэлбэр, хууль, зарчим d. Хэл ба сэтгэхүйн харилцан хамаарал
53. Дараах ойлголтуудаас аль нь ерөнхий ойлголт вэ?
- а. Автомашин б. Ачааны машин с. Жийп d. Сүүдлын машин
54. Дараах хос ойлголтуудаас аль нь зэрэгцэх харилцааг илэрхийлэх вэ?
- а. Нохой ба амьтан
б. Эмч ба сувилагч
с. Шувуу ба далавчит амьтан
d. Машин ба автомашин
55. “Мэдээллийг цахим орчинд солилцох сүлжээний орчинг интернет гэнэ” хэмээх тодорхойлолтыг задлан шинжилж зөв харгалзуулаарай
- | | |
|---|---|
| 1. Тодорхойлогдож буй ойлголт | а. Сүлжээний орчин |
| 2. Тодорхойлж буй ойлголт | б. Мэдээллийг цахим орчинд солилцох |
| 3. Тодорхойлогдож буй ойлголтын төрөл ойлголт | с. Интернет |
| 4. Тодорхойлогдож буй ойлголтын дүрсийн ялгаа | d. Мэдээллийг цахим орчинд солилцох сүлжээний орчин |
- а. 1a, 2b, 3c, 4d б. 1b, 2a, 3c, 4d с. 1a, 2c, 3b, 4d d. 1c, 2d, 3a, 4b
56. Бодомжийг аливаа өгүүлбэрээс ялгах гол шалгуур юу вэ?
- а. Бодомжийн үнэн, зөв байх шинж б. Бодомжийн үнэн, эсвэл худал байх шинж
с. Бодомжийн зөв, эсвэл буруу байх шинж d. Бодомжийн худал, эсвэл буруу байх шинж
57. Индуктив оюун дүгнэлтийг бүрэн ба бүрэн бүс гэж ангилах гол шалгуурыг нэрлэ.
- а. Судалж буй үзэгдэл, юмсын тоо, хязгаар б. Судлаачийн хүсэл, сонирхол
с. Судлагдахууны гол шинж тэмдгүүд d. Судалгааны арга



58. Аналоги гэж юу вэ?

а. Ямар нэг юм үзэгдлийг мэдэгдэж байгаа ерөнхий зарчим дээр нь үндэслэн ерөнхий шинжтэй мэдлэгээс хэсгийн шинжтэй мэдлэг гаргаж авах логик үйлдэл

б. Нэгж үзэгдлийн гол шинжүүд сонирхож буй нэгж үзэгдлийн гол шинжтэй ижил төсөөтөйд үндэслэн бусад шинж тэмдгээрээ энэ хоёр үзэгдэл ижил байх бололцоог тогтоодог логик үйлдэл

с. Юмс үзэгдлийн анги, бүлгийг нийтэд нь үл хамран, зөвхөн хэсгийн тухай тусгаар мэдлэгээс тухайн анги бүлгийн бүх гишүүдэд хамааралтай, ерөнхий дүгнэлт гаргаж авах логик үйлдэл

д. Хэзээ ч бүгдийг нь нэг бүрчлэн бүртгэж, түршиж, ажиглаж болохооргүй объект, юмс үзэгдэлд нийтлэг байдаг ерөнхий мэдлэгийг гаргаж авах логик үйлдэл

59. Эргэцүүлэлд логикийн ямар хуулийн шаардлагыг зөрчиж байна вэ?

Канад улс нутаг дэвсгэрийн хувьд том. АНУ бас том улс. Иймд Хойд америкийн бүх нутаг дэвсгэрийн хувьд том.

а. үгүйсгэлийн үгүйсгэлийн хууль

б. Зөрчилгүйн хууль

с. Гуравдахийг үгүйсгэх хууль

д. Хангалттай үндэслэлийн хууль

60. Өгөгдсөн нөхцөлөөс ямар үр дагавар гарах вэ? Бүх шувуу нийсдэг. Тахиа бол

а. Нисдэг

б. Нисдэггүй

с. Зарим үед ниснэ.

д. Нисдэг байж болно.

61. Аль нь логикийн хувьд зөв дүгнэлт вэ?

а. Бүх шатарчид бол тамирчид мөн. Бүх тэшүүрчид бол тамирчид мөн. Иймээс бүх шатарчид бол тэшүүрчид мөн.

б. Зарим шувуу нисдэггүй. Болжмор бол шувуу. Иймээс зарим болжмор нисдэггүй.

с. Энэ байшин улаан, улаан бол өнгө, харин өнгө бол оптикийн үзэгдэл, иймээс энэ байшин оптикийн үзэгдэл мөн.

д. Бүх загас усанд амьдардаг. Акүл бол загас, иймээс акүл усанд амьдардаг.

62. Эрх зүйн сэтгэлгээнд хэвшиж тогтсон "зохиомол" загварыг эвдэж деконструкци хийх нь чухал гэх хандлага аль үзэл баримтлалд хамааралтай вэ?

а. Эрх зүйн постмодернизмд хамааралтай

б. Позитив эрх зүйн онолд хамааралтай

с. Эрх зүйн социологийн онолд хамааралтай

д. Бүх онолын үрсгалд энэ асуудлыг авч үздэг

63. Аль бодомж зөв бэ?

а. Хүчингүй болсон хуулиуд эрх зүйн эх сурвалж мөн

б. Хэлэлцэгдэж буй хуулиуд эрх зүйн эх сурвалж мөн

с. Өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж буй бүх эрх зүйн хэм хэмжээ эх сурвалж мөн

д. Бүгд зөв

64. Иргэн А нь барилгын компанитай орон сууц захиалгын гэрээ байгуулж, байрны төлбөр болох 100 сая төгрөгийг төлжээ. Тус компани орон сууцыг ашиглалтад оруулах гэрээгээр тохирсон хугацааг 3 жилээр хэтрүүлсэн байна. Иргэн барилга ашиглалтад орохыг хүлээх боломжгүй байгаа тул гэрээний төлбөрт өгсөн мөнгөө буцаан авах хүсэлтэй байв. Тэрээр хуулийн дагуу ямар алхам хийх вэ?

а. Барилгын компанид хандаж гэрээнээс татгалзах хүсэлт гаргана

б. Барилгын компанид хандаж гэрээ цуцлах хүсэлт гаргана

с. Шүүхэд хандаж мөнгөө буцаан авах шаардлагатай нэхэмжлэл гаргана

д. Эвлэрүүлэн зүүчлэлд хандаж мөнгөө буцаан авах шаардлагатай нэхэмжлэл гаргана

65. Аль нь Үндсэн хуулийн цэцийн шийдвэр вэ?

а. Дүгнэлт

б. Тогтоол

с. Магадлал

д. Дээрх бүгд



66. Иргэн А нь интернэт банкаар гүйлгээ хийхдээ данс андуурч, үл таних Б-гийн дансанд 350 000 төгрөг шилжүүлсэн байна. Б түс мөнгөөр гар утас худалдан авчээ. Түүнд хуулийн дагуу ямар хариуцлага оногдуулах вэ вэ?
- Дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ
 - Учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно
 - 350 000 төгрөгийг ашигласан хоног тутам 0.5 хувиар алданги тооцож, нөхөн төлүүлнэ
 - Энэ талаар хуульд тодорхой зохицуулалт тусгагдаагүй
67. Аль нь хуульчилсан акт буюу захиргааны хэм хэмжээний актын шинжид үл хамаарах вэ?
- Хуулиар тусгайлан эрх олгосон
 - Нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан
 - Захиргааны байгууллагаас гаргасан
 - Тодорхой нэг тохиолдлыг зохицуулж, захирамжилсан
68. Хэнд нь харгалзан дэмжигч тогтоох вэ?
- Бага насны /14 нас хүрээгүй/ бүтэн өнчин хүүхэд
 - Эцэг, эх нь хоёулаа удаан хугацаагаар эмнэлэгт эмчлүүлж байгаа, хорих газарт ял эдэлж байгаа зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар хүүхдээ биечлэн тэжээн тэтгэх, асран халамжлах бололцоогүй хүний бага насны хүүхэд
 - Сэтгэцийн өвчний улмаас шүүхээс иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй гэж тооцогдсон хүн
 - Насанд хүрээгүй /14-өөс 18 хүртэлх насны/ бүтэн өнчин хүүхэд
69. Аль нь иргэний эрх зүйн харилцаа үүсэх үндэслэл вэ?
- Гэм хор учруулах
 - Үндэслэлгүй эд юм олж авах
 - Оюуны үнэт зүйл бүтээх
 - Дээрх бүгд
70. Аль нь Хүний Эрхийн Үндэсний комиссын чиг үүрэгт үл хамаарах вэ?
- Хүний эрхийн боловсролыг дэмжих, түгээх
 - Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой аливаа асуудлаар санал, зөвлөмж гаргаж, эрх бүхий байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдэд хүргүүлэх
 - Хүний эрх зөрчигдсөн эсэх асуудлаар шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад санал, дүгнэлт гаргаж хүргүүлэх
 - Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбогдсон хууль тогтоомжийг боловсронгуй болгох тухай саналаа хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжлах
71. Аль нь Эрүүгийн хуульд заасан өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт үл хамаарах вэ?
- Бусдын эд хөрөнгийг хамгаалахад хайнга хандах гэмт хэрэг
 - Болгоомжгүйгээр эд хөрөнгө устгах гэмтээх, үрэгдүүлэх гэмт хэрэг
 - Эд хөрөнгө устгах гэмтээх гэмт хэрэг
 - Булаах гэмт хэрэг
72. "Ойн зах" хэмээх том зураг дээр зураач ажиллаж байна. 1 цагийн ажлын үеэр хоёр хус мод эсвэл таван сарнай цэцэг зурж чаддаг. Зураач өдөрт 10 цаг ажилладаг. Хус модыг будах алдагдсан боломжийн зардал нь тогтмол байдаг бол арван хоёр сарнай цэцэг зухах алдагдсан боломжийн зардлыг ол
- 2,5 хус мод
 - 4,8 хус мод
 - 5/24 хус мод
 - 1/6 хус мод



73. Хэрэв орлого 3%-иар өсөх нь тухайн барааны эрэлтийг 6%-иар бууруулахад хүргэдэг бол X барааны орлогоос хамаарах эрэлтийн мэдрэмж хэд вэ?
 а. 0.5; б. -0.5 с. -2 d. Байхгүй
74. Тодорхой гарцын түвшинд барааны үнэ нь ахиуц зардлаас бага байна. Компани:
 а. гарцыг нэмэгдүүлэх ёстой б. гарцыг бууруулах ёстой
 с. гарцыг өөрчлөх ёсгүй d. үйлдвэрлэлээ зогсоох ёстой
75. Богино хугацаанд пүүс 1000 нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Дундаж хувьсах зардал 150 төгрөг, дундаж нийт зардал 250 төгрөг байна. Пүүсийн нийт тогтмол зардал хэд байх вэ?
 а. 100 төгрөг; б. 15000 төгрөг; с. 25000 төгрөг; d. 100000 төгрөг.
76. Хэрэв улсын нийт хүн ам 140 сая хүн, хөдөлмөрийн насны хүн ам 90 сая хүн, ажил хийдэггүй хүн ам 68 сая хүн, ажилгүйдлийн түвшин 10% бол ажиллах хүчний хэмжээ хэд вэ?
 а. 90 сая хүн б. 82 сая хүн с. 80 сая хүн d. 68 сая хүн
77. Эдийн засаг дахь бодит ДНБ нь 950 тэрбум төгрөг, ажилгүйдлийн хэвийн түвшин 5%, ажилгүйдлийн бодит түвшин 7%, Оукений коэффициент 2.5 байна. Түс улсад ямар хэмжээний бүтээгдэхүүн дутуу үйлдвэрлэгддэг вэ?
 а. 25 тэрбум төгрөг б. 50 тэрбум төгрөг с. 75 тэрбум төгрөг d. 100 тэрбум төгрөг
78. Тухайн онд бодит ажилгүйдлийн түвшин 8%, хэвийн ажилгүйдлийн түвшин 6%, Оукений коэффициент 2.5 байна. Бодит ДНБ болон боломжит ДНБ-ний хоорондох харьцангуй хоцрогдлын хэмжээ нь:
 а. 2%; б. 3%; с. 4%; d. 5%;
79. Дараах зүйлсийн аль нь эрэлтийн инфляцийг үүсгэдэггүй вэ?
 а. Хэрэглэгчийн зардлын өсөлт; б. Мөнгөний эргэлтийн хүрд нэмэгдэх;
 с. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт; d. Цэргийн зардлыг бууруулах;
80. Хэрэв инфляцийн түвшин жилд 150% байсан бол энэ нь тухайн жилийн үнийн түвшин дараах хэмжээгээр өссөн гэсэн үг юм.
 а. 1.25 дахин; б. 1.5 дахин; с. 2,5 дахин; d. 2 дахин.



1	2	3	4	5	6	7	8	9	10
11	12	13	14	15	16	17	18	19	20
21	22	23	24	25	26	27	28	29	30
31	32	33	34	35	36	37	38	39	40
41	42	43	44	45	46	47	48	49	50
51	52	53	54	55	56	57	58	59	60
61	62	63	64	65	66	67	68	69	70
71	72	73	74	75	76	77	78	79	80

